

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

☒

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо

ТАЗ-ийн 2019 оны 03 тогтоол

Дагаж мөрдөх огноо

2026-01-09

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2026-01-09

Байгууллагын нэр

Боловсролын Судалгааны Үндэсний
Хүрээлэн

Нэгжийн нэр

Хүний хөгжлийн судалгааны сектор

Албан тушаалын нэр

0-5 насны хүүхдийн хөгжлийн судалгаа
хариуцсан эрдэм шинжилгээний
ажилтан

Албан тушаалын ангилал, зэрэглэл

ТҮШУ-3

Ажлын цаг

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Багшийн хөгжлийн ордон

Хөдөлмөрийн нөхцөл

Хэвийн

Онцгой нөхцөл

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, 0-5 насны Монгол хүний хөгжил, танин мэдэхүй тархи судлал, нийгэм-сэтгэл хөдлөл, суралцахуйн онол, олон улсын чиг хандлагын талаар судалгаа, шинжилгээ хийх ажлыг удирдах, тэдгээрийн үр дүнд үндэслэн Монгол хүний хөгжлийн үзэл баримтлал, бодлогын санал зөвлөмж боловсруулах, бодлого шийдвэр боловсруулахад холбогдох судалгааны мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, зөвлөн туслах, өөрийн мэргэжлийг тасралтгүй хөгжүүлэх, эрдэм шинжилгээний бүтээл гаргах, оролцогч талууд, судлаачидтай хамтран ажиллах

Албан тушаалын зорилт:

- Хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцахуйтай холбоотой хууль тогтоомж, бодлого, түүний хэрэгжилтийн талаар судалгаа, шинжилгээ хийх, 0-5 насны хүүхдийн хөгжил, төлөвшилд гарч байгаа өөрчлөлтийг тодорхойлох, тэдгээрийн үр дүнд үндэслэн хүүхдийн хөгжил, суралцахуйн талаарх бодлогын шинэчлэл, өөрчлөлтийн үндэслэлийг тодорхойлох;
- Хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцахуйн онол, олон улсын чиг хандлагын талаар

судалгаа хийх, тэдгээрийн үр дүнд үндэслэн 0-5 насны Монгол хүүхдийн хөгжил, төлөвшил, сургалтын хөтөлбөр, гарын авлагад тусгах санал, зөвлөмжийг боловсруулах, суралцахуйн хэв маяг, үе хоорондын ялгааны талаар зөвлөмж боловсруулах, үр дүнг холбогдох талуудад хэлэлцүүлэх, хүүхдийн хөгжил төлөвшил, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн талаар бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах; 3. 0-5 насны хүүхдийн хөгжил, төлөвшлийн чиглэлээр боловсролын сургалтын байгууллага, төрийн болон бус байгууллага, хувь хүмүүс, судлаачтай хамтран ажиллах, судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг нийтийн хүртээл болгох, судалгааны мэдээллийн сан үүсгэх, олон нийтэд таниулах; 4. Байгууллагын болон нэгжийн төлөвлөгөө боловсруулахад оролцох, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, өөрийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг ханган ажиллах, мэргэжлээрээ тасралтгүй суралцах, эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл гаргах 5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Т ¹ , Г ² , Х ³ , Ш ⁴
Зорилт 1-ийн хүрээнд	– Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Боловсролын ерөнхий болон дагалдах хууль, Инновацийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баримталж ажиллах; – 2-5 насны Монгол хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцахуйн судалгаа, түүнтэй холбоотой хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаарх судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, сайжруулах санал, зөвлөмж боловсруулах; – Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад үндэсний хөтөлбөрүүдэд 0-5 насны хүүхдийн хөгжлийн талаар тусгасан бодлого, арга хэмжээний талаар судалгаа, шинжилгээ хийх, санал боловсруулах; – Судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн бага насны хүүхдийн хөгжлийн бодлогын шинэчлэл, өөрчлөлтийн үндэслэлийг тодорхойлох, бодлогын санал боловсруулах.	Хууль тогтоомж, бодлого, арга хэмжээний талаарх судалгааны тоо Боловсруулсан сургалтын хөтөлбөрийн тоо Боловсруулсан хувилбарт саналын тоо	Г
Зорилт 2-ийн хүрээнд	– 0-5 насны Монгол хүүхдийн хүүхдийн хөгжил, танин мэдэхүйн тархи судлал, нийгэм-сэтгэл хөдлөл, суралцахуйн олон улсын чиг хандлагын талаар судалгаа хийх, судалгааны төсөл	Судалгааны ажлын тоо	Г

¹ Туслах

² Гүйцэтгэх

³ Хянах

⁴ Шийдвэрлэх

	удирдах, санал, зөвлөмж боловсруулах; – 0-5 насны хүүхдийн хөгжлийн талаар бодлого, шийдвэр боловсруулахад шаардлагатай судалгааны мэдээллээр хангах, хувилбарт санал боловсруулах; – 0-5 насны Монгол хүүхдийн хөгжлийн бодлогын санал, зөвлөмжийг холбогдох талуудаар хэлэлцүүлэх, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.	Боловсруулсан хувилбарт санал, зөвлөмжийн тоо Уулзалт хэлэлцүүлгийн тоо, үр дүн	
Зорилт 3-ын хүрээнд	– 0-5 насны хүүхдийн хөгжил, танин мэдэхүйн тархи судлал, нийгэм-сэтгэл хөдлөл, суралцахуйн судалгааны чиглэлээр боловсролын сургалтын байгууллага, төрийн бус байгууллага, хувь хүмүүс, судлаачтай хамтран ажиллах, хамтарсан судалгаа хөгжүүлэлтийн төсөл хэрэгжүүлэх; – Нэгжид хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг сурталчлах, нийтийн хүртээл болгох, судалгаа, шинжилгээний мэдээллийн сан үүсгэх; – Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг сайжруулах, судалгаа, арга зүйн бүтээлийн чанарт ахиц гаргах; – Судалгаа, арга зүйн бүтээлээ үндэсний болон олон улсын импакт фактортай сэтгүүлд хэвлүүлэх; – Эрдэм шинжилгээний бүтээлээ хэвлэн нийтлэх, хүрээлэнгийн болон нэгжийн судалгааны хүрээнд эрдэм шинжилгээний бичиг, мэдээлэл (бюллетень), сэтгүүл, сонин зэрэгт бүтээлээ нийтлүүлэх; – Үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, симпозиумд оролцох, илтгэл танилцуулга хийх; – Судалгааны үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв бодитой мэдээлэх; – Эрдэм шинжилгээний ном, өгүүлэл, хөтөлбөр, гарын авлагыг олон нийтийн мэдээлэл (вэб сайт, телевиз, радио, өдөр тутмын сонин гэх мэт)-ийн хэрэгслээр бодлого, төлөвлөгөөтэй сурталчлах.	Судалгааны ажлын тоо Хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийн тоо, үр дүн Мэдээллийн санд бүртгүүлсэн бүтээлийн тоо	Г
Зорилт 4-ийн хүрээнд	– Хүрээлэнгийн урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлахад хамтран ажиллах, нэгжид хамаарах үр дүнг тайлагнах, эрдэм шинжилгээ, судалгааны явц, үр дүнд дүгнэлт гаргах; – Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагаанд мөрдөх дүрэм,	Байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлтийн хувь Гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Г

	журам, заавар боловсруулах, хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, шийдвэр гаргахад оролцох; – Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах; – Мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх, судалгаа, арга зүйн бүтээлийн чанарт ахиц гаргах; – Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран ажиллах, хамтарсан судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийх.	биелэлтийн хувь, хагас жил/жилийн эцсээр Судалгаа, шинжилгээний ажлын чанар, үр дүнд гарсан ахиц Хамтын ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн	
Зорилт 5-ийн хүрээнд	– Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, мэдээлэл судалгааг шуурхай, чанартай гаргаж өгөх; – Хуульд заасан чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох хуулийн дагуу байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж, тэднээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судалж барагдуулах; – Эрдэм шинжилгээ, судалгааны болон боловсролын байгууллага, иргэдтэй чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх; – Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах; – Байгууллагын дүрэм, дотоод журмын мөрдөх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг сахиж, ажлын хариуцлага, үг хэллэг, харилцаа, хандлагаар үлгэрлэн манлайлах.	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын гүйцэтгэл, чанар Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо Мэдээлэл, зөвлөгөөний тоо Авлигын эрсдэлийн үнэлгээний үр дүн Байгууллагын болон нэгжийн удирдлага, хамт олны үнэлгээ	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Боловсрол судлал /011101/, Багш, сургуулийн өмнөх боловсрол /0112/, сэтгэл судлал /0313/
Мэргэшил	Эрдэм шинжилгээний дадлагажигч болон дэд ажилтны зэрэг дэвтэй
Туршлага	Боловсролын салбарт 8-аас доошгүй жил, үүнээс эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан.
Ур чадвар	- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх ур чадвартай; 0-5 насны хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцахуйн талаар мэдлэг чадвартай;


	• Хүний хөгжлийн судалгааны арга зүй, тоон болон чанарын өгөгдөл мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх ур чадвартай; • Судалгааны програм хангамжийг ашигладаг, хэрэглээний програмуудыг эзэмшсэн байх; • Өгөгдөлд шинжилгээ хийх ур чадвартай; • Гадаад хэлээр эрдэм шинжилгээний бичиг боловсруулах, харилцах, эх сурвалж ашиглах дундаас доошгүй түвшний ур чадвартай; • Багийг удирдах, манлайлах, багаар ажиллах ур чадвартай; • Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх.
--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

V.

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	1. Захирал 2. ЭНБД 3. Секторын эрхлэгч
Албан тушаалд шууд харьяалуулан удирдуулах албан тушаалын нэр, тоо	
Бусад харилцах субъект	1. Бүх түвшний боловсролын байгууллагууд 2. Багш, эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн 3. Төрийн бус байгууллагууд 4. Эцэг эх, асран хамгаалагчид, хүүхэд

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	
Албан тушаал: ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН	
 О.ОЮУНТУНГАЛАГ (Гарын үсэг) 2026 оны 01 дүгээр сарын 09 -ний өдөр	
<u>Албан тушаалын тодорхойлолт баталсан</u>	
Байгууллагын нэр: БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН	
Шийдвэрийн огноо: 2026 оны 01 дүгээр сарын 09 -ний өдөр	
Дугаар:	
(тамга/ тэмдэг)	
ЗАХИРАЛ	
 (Гарын үсэг) 9022020670 9080686	/П.ОЮУНАА/ (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
2026 оны 01 дүгээр сарын 09 -ний өдөр	